



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Албан тушаал (ажлын байр)-ын жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, 2023 оны 240 дүгээр тогтоол, 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/52 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус газрын бүтэц, орон тооны схемийг нэгдүгээр, албан тушаал (ажлын байр)-ын жагсаалтыг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2024 оны “Албан тушаал (ажлын байр)-ын жагсаалт батлах тухай” А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Батлагдсан албан тушаал (ажлын байр)-ын жагсаалтын дагуу албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний
өдрийн А/03 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
АЛБАН ТУШААЛ (АЖЛЫН БАЙР)-ЫН ЖАГСААЛТ

д/д	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Газрын дарга	ТЗ-3	1
Захиргаа, санхүүгийн хэлтэс			
2	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	ТЗ-4	1
3	Бодлогын баримт бичгийн тайлан, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-7	1
4	Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
5	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
6	Ахлах нягтлан бодогч	ТҮМ-7	1
7	Архив, бичиг хэргийн эрхлэгч	ТҮМ-3	1
8	Нярав	ТҮ-4	1
Бодлогын хэрэгжилтийн хэлтэс			
9	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга	ТЗ-4	1
10	Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-7	1
11	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
12	Эвент хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	2
13	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
14	Аялал жуулчлалын байгууллага, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс			
15	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга	ТЗ-4	1
16	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-7	1
17	Маркетинг сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
18	Цахим хөгжүүлэлт, мэдээллийн технологи хариуцсан ажилтан	ТҮ-7	1
19	Жуулчны аюулгүй байдал, мэдээллийн төвүүд хариуцсан менежер	ТҮ-8	1
Нийт тоо			20
Төрийн захиргааны албан хаагч-15			
Төрийн үйлчилгээний албан хаагч-5			

Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн
А/03 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЦИЙН СХЕМ



Төрийн захиргааны албан хаагч - 15

Төрийн үйлчилгээний албан хаагч - 5